



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/406

Арвайхээр сум

**Бүтэц, орон тоонд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Байгууллагын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/75 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан орон тооны үйлчлэгч 3 гэснийг “2” гэж, шинээр бичиг хэрэг, архивч, нярав-1 гэж өөрчилсүгэй.

2. Бүтэц, орон тоонд шинээр өөрчлөлт орсонтой холбогдуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Хархорин сумын Спортын ордны дарга (Б.Батдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0798

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 21-ны өдрийн 1106 дугаар
захирамжийн хавсралт
хавсралт



**ХАРХОРИН СУМЫН СПОРТЫН ОРДНЫ БҮТЭЦ, ОРОН ТООНЫ
ШИНЭЧИЛСЭН ӨӨРЧЛӨЛТ**

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1.	Дарга	1
2.	Арга зүйч	1
3.	Дасгалжуулагч	2
4.	Нягтлан бодогч	1
5	Бичиг хэрэг, архивч, нярав	1
6	Жижүүр	4
7	Үйлчлэгч	2
Бүгд		12

-оОо-